



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/85

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 48 дугаар зүйлийн 48.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 100 жилийн ойг тохиолдуулан иж бүрэн гэр нийлүүлэх ажлыг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)  
Гишүүд: Ж.Батмөнх (Байгаль хамгаалагч)  
Г.Хулан (Нийгмийн ажилтан)

2. Худалдан авах ажиллагааны техникийн тодорхойлолтыг боловсруулан 3-аас доошгүй иргэн, аж ахуйн нэгжээс үнийн санал авч нийлүүлэгчийг сонгон шалгаруулахыг Ажлын хэсгийн ахлагч (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА САМГАЛАН

